

**“ГТХЗНТ” УТҮГ-ЫН ЗАХИРЛЫН ТУШААЛЫН ХЭРЭГЖИЛТЭД  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2024 оны 3 сарын 12-ны өдөр

Дугаар03

“ГТХЗНТ” УТҮГ

“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-ЫН захирлын хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд батлан гаргасан 15 тушаалын 21 заалтыг бүртгэлээр хяналтад авч, биелэлтийг тооцов.

Захирлын тушаалын хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ хийхэд бүрэн хэрэгжсэн 6, хэрэгжих шатанд 2, хэрэгжилт хангалтгүй 2, хэрэгжээгүй 5, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 3, хүчингүй болсон 2, үнэлээгүй 1 заалттай, 53.3 хувийн хэрэгжилттэй байна.

Захирлын тушаалаар нэгж, ажилтанд өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хариуцан хэрэгжүүлэх нэгж, ажилтан тус бүрээр гаргавал дараах байдалтай байна:

№	Нэгж, ажилтны нэр	Нийт заалт	Үүнээс							Биелэлт /хувиар/
			100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	Үнэлээгүй	
1	М.Оюун-Ундрам	6	-	1	-	4	-	-	1	0
2	Д.Амарзаяа	1	1	-	-	-	-	-	-	100
3	Ажлын хэсэг	5	1	1	1	1	1	-	-	50
4	Г.Баттөр, Т.Мейрамбек	1	1	-	-	-	-	-	-	100
5	Ж.Алимаа	1	-	-	1	-	-	-	-	30
6	С.Золзаяа	2	1	-	-	-	1	-	-	100
7	ЗСХ	2	1	-	-	-	-	1	-	100
8	ГХБАБМХ	1	-	-	-	-	-	1	-	-
9	Ц.Оюунбат, Ж.Алимаа	2	1	-	-	-	1	-	-	1
Дүн		21	6	2	2	5	3	2	1	53.3

Хяналтад байгаа 15 тушаалыг агуулгын хувьд ангилахад төлөвлөгөө баталсан 2, заавар, дүрэм баталсан 2, журам, заавар хүчингүй болгох тухай 2, ажлын хэсэг томилсон 2, тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2, жагсаалт, хуваарь баталсан 2, хариуцлагатай жижүүр томилох, тэтгэлэг олгох, аян зохион байгуулах тухай тус бүр 1 тушаал байна.

Тушаалын заалтын 33.3 хувь буюу 7 нь байнгын шинжтэй, 66.7 хувь буюу 14 нь нэг удаагийн үүрэг даалгавар хэрэгжүүлэхтэй холбоотой заалт байна.

Тушаалын хэрэгжилтийн байдлыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

**Санал, зөвлөмж:**

- Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт MNS 6630:2016 стандартад нэмэлт, өөрчлөлт оруулах, сайжруулж боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн нарийн бичгийн дарга өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөгдсөн, хариуцсан мэргэжилтэн жирэмсний болон амаржсаны амралттай байгаа тул тус ажлыг хөдлөх бүрэлдэхүүний мэргэжилтэнд хариуцуулж СХЗГ-т

хүргүүлсэн стандартын төслийг Төмөр зам, далай ашиглалт, усан замын тээврийн стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэх арга хэмжээ авах;

2. Төвийн ажил мэргэжлийн жагсаалт 2023.11.13-ны өдөр батлагдсан, тушаалын 2 дахь заалтаар ажил мэргэжлийн жагсаалтын дагуу албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулахыг үүрэг болгосон энэхүү ажил хэрэгжээгүй 4 сарын хугацаа өнгөрч байна. Албан тушаалын тодорхойлолтуудыг тайлант сард батлуулаагүй тохиолдолд хариуцсан ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах;

3. ЗТХ-ийн сайдын 2023 оны 01, 2024 оны 02 дугаар шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу салбарын бодлого, үйл ажиллагаа, үр дүнг нийгмийн сүлжээгээр сурталчлах чиг үүргийг албан тушаалын тодорхойлолтод, салбарын бодлого, шийдвэрийг олон нийтэд сурталчлах үүргийг хөдөлмөрийн гэрээнд нэмэлтээр тус тус тусгасан тул Зам, Тээврийн Хөгжлийн Яам хуудсыг дагаж мэдээ, мэдээллийг хуваалцах;

4. Захирлын 2024 оны A/01 дүгээр тушаалаар баталсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг сурталчлах, хэрэгжилтийг хангуулах”, “ХАБЭА-н хяналтын журам, ХАБЭА-н заарыг нэгтгэж, өөрчлөлт оруулах” гэсэн 2 ажил тасарсан буюу хэрэгжээгүй байгаад анхаарч төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлэх;

5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2024.01.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөнтэй холбогдуулан захирлын 2024 оны A/02 дугаар тушаалаар батлагдсан үнэлгээний хороо Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2024.03.05-ны өдрийн A-2/1148 дугаартай албан бичгээр өгсөн зөвлөмжийн дагуу тендерийн үйл ажиллагааг зохион байгуулах;

6. Захирлын 2024 оны A/03 дугаар тушаалаар баталсан 7 зорилт, 22 арга хэмжээ бүхий Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг 2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан 10 ажил тасарсан буюу хэрэгжээгүй, 2 ажил хэрэгжилт хангалтгүй байгаад дүгнэлт хийж төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэх. Үүнд:

- a) Ажилтны мэдлэг, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх
- b) Төвийн албан хаагчдыг төрийн албан хаагчийн сургалтад бэлдэх, шалгалтад хамруулах
- c) Сул орон тооны мэдээллийг нийтэд мэдээлж, мерит зарчим баримтлах
- d) Төмөр замын тээврийн дээд сургуультай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд шинэ төгсөгчдийг ажлын байраар хангах
- e) Ажилтны үр дүнгийн үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан цалингийн шатлал ахиулах асуудлыг шийдвэрлүүлэх
- f) Хүний нөөцийн стратеги, хөгжлийн хөтөлбөр түүний хэрэгжилтийг цахим хуудсандaa ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх
- g) Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандaa ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх
- h) Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн чиглэлээр холбогдох мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулж шинэчлэх
- i) Төвийн ёс зүйн хорооны үйл ажиллагаа, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн талаарх мэдээ, мэдээллийг тухай бүр вэб сайтад байршуулах

j) Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах


k) Ажилтны ажлын байрны ёс зүй, хариуцлагын асуудлыг хөдөлмөрийн дотоод хэм, хэмжээнд нарийвчлан тусгах


l) Авила, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах


7. Баримт нягтлан шалгах комиссыг хуралдуулж, дүрмийг танилцуулах, 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж хэлэлцэх;

8. Захирлын тушаалаар үүрэг болгосон, даалгасан ажлыг ажил, үүргийн чиглэлийн дагуу хугацаанд нь гүйцэтгэж, үр дүнг мэдээлэх, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнг хариуцаж Хөдөлмөрийн дотоод журмын 5.2.7-д заасны дагуу тайлагнах.


**ТАНИЛЦСАН:**

“ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН  
НЭГДСЭН ТӨВ” УТҮГ-ЫН ЗАХИРАЛ  A.BUYANNEME

ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ, ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН  
АШИГЛАЛТ, БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА  C.O尤UNBAT

ТЭЭВРИЙН НЭГДСЭН УДИРДЛАГА, АВТОМАТЖУУЛАЛТ,  
СУДАЛГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, ЗУРМАГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  Ж.АЛИМАА

**БОЛОВСРУУЛСАН:**

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН  
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
МЭРГЭЖИЛТЭН  Э.ОСОРЖАМАА  
